



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 265

Улаанбаатар хот

**Үл хөдлөх хөрөнгийг бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 2,737,060,204.67 (хоёр тэрбум долоон зуун гучин долоон сая жаран мянга хоёр зуун дөрвөн төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг Гадаадын иргэн, харьяатын газар (Баруун бүс дэх газар)-т хавсралтад заасны дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 25 дугаар сарын 25-ны өдрийн
263 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БАРЬСАН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР (Баруун бүс дэх газар)-ЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөгөөр)	Улсын комиссын акт		Бүртгэж авах хуулийн этгээдийн нэр
				огноо	дугаар	
1	Баруун бүс дэх газрын барилга (Ховд аймаг, Жаргалант сум, Тахилт баг)	952,61 м2 талбайтай /21.0*12.0 м хэмжээтэй зоорьтой 3 давхар/ цутгамал төмөр бетон үндсэн хийцтэй, караказ	2,389,788,396.00	12/8/2023	ББКД-84-33/23	ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗАР
2	Дулааны шугам /гадна/	17.8 метр урттай яндан хоолой Ф32 мм	48,772,299.26	10/15/2024	ББКД-22/2024	
3	Цэвэр, бохир усны шугам /дотор/	D-50 мм голчтой ган хоолой, яндан хоолой Ф32*2.5мм, нийт хоолойн урт 17.8м	4,197,480.17			
4	Цахилгааны шугам /гадна/	D-50 мм голчтой ган хоолой, яндан хоолой Ф32*2.5мм, нийт хоолойн урт 17.8м	104,923,209.78			
5	Гадна гэрэлтүүлэг	Гадна талбай гэрэлтүүлэг 5 м өндөр, d-63 мм ган хоолой бүхий13 ширхэг гэрэлтүүлэг авто зогсоолын талбай	54,191,268.00			
6	Зам талбай /зогсоол/	9*3 хэмжээтэй асбалтан хучилттай автомашины зогсоол, явган хүний зам	135,187,551.46			
	Нийт дүн		2,737,060,204.67 (хоёр тэрбум долоон зуун гучин долоон сая жаран мянга хоёр зуун дөрвөн төгрөг жаран долоон мөнгө)			